



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 3 сарын 26 өдөр

Дугаар A-76

Улаанбаатар хот

Г  
Макро зохистой бодлогын стратеги батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 22<sup>1</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2017 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсад макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэх стратеги”-ийг хавсралтаар баталсугай.

2.Макро зохистой бодлогын стратегийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчийн А-305 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг (Б.Түмэнцэнгэл)-т даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Д.Аюуш)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны  
3 дугаар сарын **16** ны өдрийн **11** дугаар  
тушаалын хавсралт



**МОНГОЛБАНК**

**МОНГОЛ УЛСАД МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН  
ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИ**

**Улаанбаатар хот  
2018 он**

## **Агуулга**

I. Нийтлэг үндэслэл.....	1
II. Макро зохистой бодлогын зорилго ба хэрэгсэл.....	1
III. Макро зохистой бодлогод баримтлах гол зарчмууд .....	3
IV. Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үе шат .....	4
V. Институцийн тогтолцоо, зохион байгуулалт .....	6
VI. Олон нийттэй харилцах харилцаа.....	8
VII. Стратегид нэмэлт, өөрчлөлт оруулах.....	10

## I. Нийтлэг үндэслэл

Үйлдвэрлэл болон экспортын төрөлжөөгүй байдал, олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнээс өндөр хамаарал, банк давамгайлсан санхүүгийн сектор зэрэг нь манай орны санхүүгийн системийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг хүчин зүйлс юм. Иймд нийт санхүүгийн салбарт доголдол үүсгэх, улмаар бодит эдийн засагт хүчтэй сөрөг үр дагавар бүхий системийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах оновчтой бодлого боловсруулан, хэрэгжүүлэх нь Монгол Улсын хувьд чухал асуудал байсаар ирсэн.

Санхүүгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх, нэгэнт хямрал нүүрлэсэн үед түүний хор хохирлыг бууруулахын тулд олон улсад макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь түгээмэл болжээ. Гэвч бүх улс оронд тохиорох нэг бодлогын жор үгүй бөгөөд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх институцийн тогтолцоо, ашиглах арга хэрэгсэл зэрэг нь аливаа улс орны эдийн засаг, санхүүгийн тогтолцоо, зохицуулагч байгууллагуудын онцлогоос хамаараад харилцан адилгүй байна.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монголбанк макро зохистой бодлого хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнтэй холбогдуулан зарим улс орны сайн туршлага, олон улсын байгууллагуудын зөвлөмжид тулгуурлан энэхүү стратегийн баримт бичгийг боловсруулав. Тус стратегид Монгол Улсад хэрэгжүүлэх макро зохистой бодлогын зорилго болон түүнд хүрэхэд ашиглагдах арга хэрэгслүүд, институцийн зохион байгуулалт, бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд баримтлах ерөнхий зарчмуудыг тодорхойллоо.

## II. Макро зохистой бодлогын зорилго ба хэрэгсэл

Монгол Улсад макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилго нь i) санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ii) санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх, iii) системийн эрсдэлээс урьдчилсан сэргийлэхэд оршино. Макро зохистой бодлого нь Монголд төдийгүй олон улсад ч харьцангуй шинэ ойлголт тул бодлогын зорилт болон шилжих механизм, бусад макро болон микро зохицуулалтуудтай хослох үр дүнгийн талаар маргаантай эсхүл нэмж судлагдах шаардлагатай зүйлс багагүй байгааг Монголбанк хүлээн зөвшөөрч, гагцхүү нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн өндөр түвшинд байлгахад чиглэж хэрэгжүүлнэ.

Өнгөрсөн хугацаанд эдийн засагт нүүрлэсэн хүндрэл, хямралуудаас харахад санхүүгийн тогтвортой байдал хангагдахад дараах 3 төрлийн эрсдэлийг оновчтой удирдах зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Зээлийн хэт өсөлт (аль нэг бүтээгдэхүүн, салбар, эсхүл нийт зээлийн хэмжээ) болон хөшүүргийн эрсдэл
2. Актив пассивын хооронд валютын, эсхүл хугацааны зөрүү үүсэх эрсдэл
3. Төвлөрлийн эрсдэл (аль нэг эдийн засгийн сектор, эсхүл валют гэх мэт) болон системийн хувьд ач холбогдолтой банкны эрсдэл

Эдгээр эрсдэлүүдийг оновчтой удирдах, бууруулахад олон улсад өргөн хэрэглэгддэг дараах хэрэгслүүдээс сонголт хийх боломжтой (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Түгээмэл ашиглагддаг макро зохистой бодлогын хэрэгслүүд**

Зорилго	Хэрэгслүүд
Зээлийн хэт өсөлт, хөрөнгийн үнэ хөөсрөхөөс үүсэх эрсдэлийг бууруулах зорилготой хэрэгслүүд	<ul style="list-style-type: none"> <li>■ Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгө (Countercyclical capital buffer)</li> <li>■ Динамик эрсдэлийн сан (Dynamic loan loss provision)</li> <li>■ Зээл-үнэлгээний харьцаа (Loan-to-value ratio)</li> <li>■ Өр-орлогын харьцаа (Debt-to-income ratio)</li> <li>■ Заавал байлгах нөөц (Reserve requirement)</li> <li>■ ТТГЧ-ын харьцаа (Liquidity coverage ratio)</li> <li>■ Цэвэр тогтвортой эх үүсвэрийн харьцаа (Net stable funding ratio)</li> <li>■ Хөшүүргийн харьцаа (Leverage ratio)</li> <li>■ Ногдол ашиг тараахыг хязгаарлах (Restriction on profit distribution)</li> <li>■ Зээлийн хэмжээ эсвэл өсөлтөд хязгаар тогтоох (Caps on credit or credit growth)</li> </ul>
Хөрвөх чадвар, хугацааны зөрүү, валютын зөрүү зэрэг системийн хэмжээнд эрсдэл хуримтлуулдаг үндсэн механизмуудыг хязгаарлах зорилготой хэрэгслүүд	<ul style="list-style-type: none"> <li>■ Актив, пассивын хугацааны зөрүүний хязгаарлалт (Limits on maturity mismatch)</li> <li>■ Валютын нээлттэй позицийн хязгаарлалт (Limits on net open currency position)</li> <li>■ Гадаад валютын зээлийн хязгаарлалт (Caps on foreign currency lending)</li> <li>■ Үндсэн бус үйл ажиллагааны эх үүсвэрийн татвар (levy on non-core funding)</li> </ul>
Системд эрсдэл тархах боломж болон системийн бүтцээс үүдэлтэй эрсдэлүүдийг хязгаарлах зорилготой хэрэгслүүд	<ul style="list-style-type: none"> <li>■ Ханшийн эрсдэлтэй иргэд, ААН-д олгосон гадаад валютын зээлийн эрсдэлийн жин (Risk weight)</li> <li>■ Системийн ач холбогдолтой банкны эрсдэл шингээх чадварыг сайжруулах (Capital surcharges on SIFIs)</li> <li>■ Сектороор ялгаатай өөрийн хөрөнгийн харьцаа тогтоох (Sectorial Capital Requirements)</li> <li>■ Эх үүсвэрийн төвлөрөл (Concentration of funding)</li> </ul>

Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхдээ нэг эсхүл хэд хэдэн хэрэгслийг ашиглах боломжтой бөгөөд, аль үед ямар хэрэгслийг ашиглах нь тухайн нөхцөл байдал, үссэн эрсдэлээс шалтгаална. Хэдийгээр макро зохистой бодлого нь нийт санхүүгийн системийг хамрах учиртай ч, дээрх арга хэрэгслүүдийн үйлчлэх хүрээ нь үндсэндээ банкны сектороор хязгаарлагдаж байгаа нь Монголын санхүүгийн зах зээлд банкны секторын эзлэх орон зай, үзүүлэх нелөө нь үлэмж их байгаатай холбоотой бөгөөд банкны систем тогтвортой байх нь санхүүгийн тогтвортой байдал хангагдах чухал хүчин зүйл юм. Монголбанк системийн эрсдэлүүд болон тэдгээрийг удирдахад ашиглах хэрэгслүүдэд

үнэлэлт дүгнэлт өгч, шинэчилж сайжруулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэнэ (дэлгэрэнгүйг IV хэсэгт).

### **III. Макро зохистой бодлогод баримтлах гол зарчмууд**

Монголбанк нь макро зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэхдээ **нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн дээд түвшинд хадгалахад чиглэсэн бодлогын хослол болгох бөгөөд ингэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:**

#### **1. Макро зохистой бодлого нь Төв банкны үндсэн зорилготой нийцтэй байх бөгөөд тус бодлого болон мөнгөний бодлого нь харилцан бие биенээ нөхнө**

Мөнгөний бодлогын дам нөлөө санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үед макро зохистой бодлогоор уг сөрөг нөлөөллийг бууруулна. Тухайлбал, мөнгөний бодлогыг зөвлүүлэх үед зээлийн өсөлттэй зэрэгцээд банкуудын балансын долларжилт нэмэгдэх, өрхийн өрийн дарамт ихсэх, тодорхой нэг салбарт зээлийн төвлөрөл ихсэх зэрэг сөрөг нөлөөлөх илрэх боломжтой. Энэ үед эдгээр болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор макро зохистой бодлогын хэрэгслийг ашиглах нь үр дүнтэй шийдэл байх боломжтой.

#### **2. Макро зохистой бодлого нь бусад макро эдийн засгийн бодлогыг үл орлоно**

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад макро эдийн засгийн уламжлалт бодлогууд буюу мөнгөний бодлого, төсвийн бодлого, бүтцийн өөрчлөлтийн бодлогоор уг тэнцвэргүй байдлыг арилгана. Харин макро зохистой бодлогыг санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгоор ашиглана.

#### **3. Макро зохистой бодлого нь хөрөнгийн урсгалд нөлөөлөх бодлогын арга хэрэгсэлтэй ижил байж болно**

Хөрөнгийн урсгал, валютын ханишийн шокоос үүдэлтэй эмзэг байдлыг бууруулах макро зохистой бодлогын арга хэрэгслүүд нь хөрөнгийн урсгалын хэмжээ, бүтцэд нөлөөлөх тул тэдгээр хэрэгслүүд хоёр өөр зорилгоор ашиглагдаж болно.


#### **4. Макро зохистой бодлого болон микро зохистой бодлогын зорилго ялгаатай байна**

Микро зохистой бодлого нь тухайлсан нэг санхүүгийн байгууллагын тогтвортой байдлыг хангахад чиглэдэг бол макро зохистой бодлого нийт санхүүгийн системийн эрсдэлийг бууруулахад чиглэдэг. Иймд микро болон макро зохистой бодлогын хэрэгслүүд нь үндсэн зорилгоороо ялгаатай байна.

#### IV. Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үе шат

Монголбанк нь макро зохистой бодлогыг дараах үе шатын дагуу хэрэгжүүлнэ (*Дүрслэл I*).

##### Дүрслэл 1. Макро зохистой бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны дараалал



##### 1. Макро зохистой бодлогын эцсийн зорилттой нийцтэйгээр завсрлын зорилтууд, түүнд чиглэсэн хэрэгслүүдийг тодорхойлж, тоон мэдээллийг цуглуулах

Олон улсын туршилагаас харахад санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлүүдийг ижил төстэй шинж чанараар дэд бүлгүүдэд (завсрлын зорилтууд) хувааж, тухайн эрсдэл бүрт тохирсон үнэлгээ хийх аргачлалыг хөгжүүлж, эрсдэлийг удирдахад чиглэсэн хэрэгслүүдийг сонгох нь оновчтой байна. Үүний эхний алхам нь шаардлагатай тоон мэдээллүүдийг цуглуулж, нэгдсэн мэдээллийн сантай болох явдал юм.

##### 2. Эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ, тоон мэдээллийг боловсруулах

Завсрлын зорилтуудыг тодорхойлон, холбогдох тооцоо судалгаанд шаардлагатай тоон мэдээллүүдийг цуглуулсны дараа санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд эрсдэлийн үнэлгээг тогтмол давтамжтай хийх, урьдач анхааруулах индикаторуудыг тооцох шаардлагатай. Иймд, санхүүгийн системийн нөхцөл байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг судалж, үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх загвар хөгжүүлэх, улмаар хуваарийн дагуу тогтмол үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах үйл ажиллагааны бүтцийг бий болгоно.

## Үүний хүрээнд:

- Санхүүгийн системийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулж мэдээллийн санг бий болгох, шинжилгээ хийн үнэлэлт дүгнэлт өгөх аргачлал загвар боловсруулж хөгжүүлэх, эрсдэлийн хэмжүүр индикаторууд болон тэдгээрийн босго утгыг тодорхойлно. Монголбанк нь санхүүгийн секторын гол бүрэлдэхүүн хэсэг болсон арилжааны банкуудын талаарх тоон мэдээллийг цуглуулах, түүн дээр шинжилгээ хийх бүрэн бололцоотой тул макро зохистой бодлогын судалгаа шинжилгээний энэ хэсэгт ихээхэн үүрэг оролцоотой байх болно.
- Макро зохистой бодлогын хэрэгслүүдийн шилжих механизмыг нарийвчлан судалж тогтоох нь аливаа эрсдэлийг оновчтой удирдах үндэс юм. Иймд Монголбанк хэрэгсэл тус бүрийн хувьд эдийн засагт, санхүүгийн системд ямар үйлчлэл үзүүлдгийг онолын хувьд болон эмпирик тохиолдолд тогтмол судалгааг хийнэ.
- Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхдээ эдийн засагт үр ашгийг хамгийн өндөр, зардлыг бага түвшинд байлгахыг зорино. Үүний тулд урьдчилсан (*ex ante*) болон гүйцэтгэл дээрх (*ex post*) зардал/үр ашгийн судалгаа (*cost/benefit analysis*)-г хийж гүйцэтгэх арга техникийг судалж, нэвтрүүлэх бөгөөд энэ нь цаашдын бодлогын арга хэмжээний оновчтой байдал, бодлогод итгэлийг дээшлүүлэхдээ чухал хувь нэмэр оруулна.
- Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхдээ ашиглах тухайн арга хэрэгсэл нь микро зохистой бодлого болон мөнгөний бодлоготой хэрхэн уялдах эсхүл сөргөлдөх талаарх үнэлгээ болон, бодлогын нөлөөлөл алдагдах эрсдэл (*leakage*)-ийг тооцох судалгааны арга техникийг нэвтрүүлнэ.

Эдгээр судалгаа шинжилгээ, тэдгээрт шаардлагатай тоон мэдээлэл цуглуулж, боловсруулж, дүгнэлт хийх мэргэжилтэн, багийг бэлдэх тогтолцоог бүрдүүлэхийн тулд Монголбанк олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах, туршилага судлах замаар Монгол Улсад шинээр хэрэгжиж эхлэх макро зохистой бодлогын боловсруулалт, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллах боловсон хүчнийг тогтмол бэлдэнэ.

### 3. Шаардлагатай тохиолдолд бодлогын санал боловсруулах

Хуваарийн дагуу тогтмол үнэлгээ хийх үед санхүүгийн системд эрсдэл үүсэх урьдач нөхцөл бүрэлдсэн шинж тэмдэг илэрвэл цаг алдалгүй Монголбанкны удирдлагад танилцуулна. Улмаар макро зохистой бодлогын эцсийн шийдвэр гаргах хуралдаанд зориулан санхүүгийн системд үүсч буй эрсдэл, түүнээс сэргийлэхэд чиглэсэн бодлогын сонголтууд, урьдач тооцоололд үндэслэсэн бодлогын үр нөлөөний шинжилгээ, шийдвэр гаргахад шаардлагатай бусад мэдээллийг агуулсан бодлогын саналыг боловсруулна. Энэхүү ажлыг эхний ээлжинд Монголбанкны бодлогын газрууд хамтран хийх бөгөөд цаашид урт хугацаанд макро зохистой бодлогыг хариуцсан бие даасан нэгж хариуцаж хэрэгжүүлдэг олон улсын жишигт нийцүүлэх арга замыг эрэлхийлнэ.

### 4. Шийдвэр гаргах, олон нийтэд мэдээлэх

Санхүүгийн системд үүсч буй эрсдэл, түүнээс сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд үнэн зөвөөр тайлбарлан таниулах нь бодлогын үр нөлөөг дээшлүүлдэг. Иймд санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн бүтэц, агуулгыг сайжруулах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх ажлыг тогтмол зохион

байгуулж, Монголбанкны дотоод ажлын төлөвлөгөөнд тусгаж байна. Мөн цаашид санхүүгийн системийг бүхэлд нь хянах, макро зохистой бодлогын шийдвэр гаргалтыг илүү оновчтой болгохын тулд зохицуулагч байгууллага (Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо) хоорондын хамтын ажиллагааг сайжруулна.

#### **5. Журам боловсруулж хэрэгжүүлэх эсвэл журамд өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавих**

Макро зохистой бодлогын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд бодлогын хэрэгслийн журмыг оновчтой тодорхойлж, хяналт тавих шаардлагатай. Иймд макро зохистой бодлогын стратегид тусгагдсан хэрэгслүүдэд холбогдох журмуудыг судлан, шаардлагатай тохиолдолд өөрчлөн найруулах, эсхүл шинээр журам боловсруулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнтэй холбоотойгоор цаашид шаардлагатай бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх эрх зүйн баримт бичгийг боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.

#### **6. Бодлогын үр нөлөөг судлах, хэрэгжилтийг хянах, тайлан боловсруулах**

Макро зохистой бодлогын хэрэгслийг нэвтрүүлснээр гарах үр нөлөөг судалж, зардал үр ашгийн тооцоог хийж, тооцооллын алдааг бууруулснаар цаашид бодлогын хэрэгслийг оновчтой сонгох, бодлогын арга хэмжээг зөв тохируулах, макро зохистой бодлогын ач холбогдлыг олон нийтэд танилцуулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах боломж дээшилнэ. Иймд макро зохистой бодлогын хэрэгслийг ашигласны дараа бодлогын үр нөлөөг судалж, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг тогтмол хийнэ.

#### **7. Бусад улсуудын туршилага судлах**

Макро зохистой бодлогод улс орнууд анхаарлаа хандуулж эхлээд удаагүй байгаа хэдий ч зарим улсууд энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гаргасан. Эдгэр орнуудын туршилагыг судалж, амжилттай туршилагыг нэвтрүүлснээр манай улсын макро зохистой бодлогын хөгжлийг хурдаасгах, улмаар санхүүгийн системд ирээдүйд үүсч болох хүндрэлүүдийг хохирол багатай даван туулахад эерэг нөлөө үзүүлэх тул олон улсын байгууллага, бусад төв банкуудтай хамтран судалгаа шинжилгээ хийх, сургалт семинар зохион байгуулах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах боломжийг эрэлхийлнэ.

### **V. Институцийн тогтолцоо, зохион байгуулалт**

Монгол Улсад макро зохистой бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бодлого боловсруулж, хэрэгжүүлэх институцийн тогтолцоо чухал үүрэгтэй. Үүнд санхүүгийн салбарын гол зохицуулагч, бодлого тодорхойлогч болох Монголбанк (Төв банк), Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам зэрэг байгууллагуудын хамтын ажиллагаа, бодлого үйл ажиллагааны уялдаа чухал ач холбогдолтой юм.

- Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгынхoo хүрээнд арилжааны банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй.

- Санхүүгийн зохицуулах хороо нь банкнаас бусад санхүүгийн салбарыг зохицуулдаг бөгөөд үүний хүрээнд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хүлээдэг. Тус хорооны үйл ажиллагааны хамрах хүрээнд үнэт цаасны зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод зэрэг багтдаг.
- Сангийн яам нь татварын бодлого, төсвийн бодлогоор дамжуулан санхүүгийн зах зээлд чухал нөлөө үзүүлдэг.
- 

Монгол Улсад макро зохистой бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх институцийн сайн тогтолцоог амжилттай нэвтрүүлэхийн тулд цаг хугацааны хувьд шат дараатай хийгдэх арга хэмжээнүүдийг тодорхойлж, тэдгээрийг хийж гүйцэтгэнэ.

#### **Эхний алхам – Богино хугацаанд**

Монгол Улсад банкнаас бусад санхүүгийн салбарын хэмжээ харьцангуй жижиг, нийт эдийн засагт үзүүлэх нөлөө нь бага тул банкны салбарын эрүүл мэнд санхүүгийн тогтвортой байдалд шийдвэрлэх нөлөөтэй байсаар ирсэн. Харин санхүүгийн зах зээлийн бусад оролцогч нар (банк бус санхүүгийн байгууллагууд, үнэт цаасны компаниуд, даатгалын компаниуд г.м.) санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулах системийн хэмжээний том эрсдэл бий болгох эрсдэл одоохондоо хязгаарлагдмал байна. Иймд санхүүгийн тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлийн үнэмлэхүү хэсгийг бүрдүүлэгч банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн Төв банкны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаатай нягт холбогдоно. Банкны салбартай холбоотой тоон мэдээлэл, макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих эрх нь Төв банкны тухай хуулиар Монголбанкинд олгогдсон тул шинжилгээ хийхээс шийдвэр гаргах хүртэлх процесийг Төв банк бие даан гүйцэтгэх эрх зүйн чадамжтай.

Тухайлбал, Төв банкны тухай хуулинд Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх талаар дараах заалтууд тусгагдсан. Үүнд:

- 5 дугаар зүйл: Монголбанкны үйл ажиллагааны чиглэл**  
8 дахь хэсэг: *Макро зохистой бодлого хэрэгжүүлэх*

- 22<sup>1</sup> дугаар зүйл: Макро зохистой бодлого хэрэгжүүлэх**

1 дэх хэсэг: *Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгслийг ашиглан хэрэгжүүлнэ.*

Макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглах тогтолцоог нэвтрүүлэх нь Монголбанк өөрт хуулиар ногдсон үндсэн зорилт болох үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хадгалах, энэхүү үндсэн зорилтынхоо хүрээнд санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй байх болно.

## **Шийдвэр гаргалт**

Макро зохистой бодлогын шийдвэрийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хуралдаанаар хэлэлцэж, гаргана. Мөнгөний бодлогын хорооны хуралдаанд оруулах бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар боловсруулах бөгөөд шаардлагатай тоон мэдээлэл цуглуулах, үнэлэлт дүгнэлт өгөхөд Төв банкны бусад гол нэгжүүдтэй хамтарч ажиллана. Энэхүү үйл ажиллагааны талаар Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж, шаардлагатай тохиолдолд энэхүү үйл ажиллагааг журмаар зохицуулна. Монголбанк макро зохистой бодлогын шийдвэрээ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд тухай бүр танилцуулж, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой тогтмол хамтран ажиллана.

## **Дунд, урт хугацаанд**

Дунд, урт хугацаанд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог тогтмол сайжруулан боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцсэн институцийн тогтолцоо, арга барилыг нэвтрүүлэхийн тулд дараах зүйлс хийгдэх шаардлагатай. Үүнд:

- Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтад Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамыг албан ёсоор оруулах,
- Макро зохистой бодлогын шийдвэр гаргах тусдаа хороотой болох,
- Макро зохистой бодлогын шийдвэр гаргахтай холбоотой тоон мэдээлэл цуглуулалт, шинжилгээ судалгаа, үнэлэлт дүгнэлт хийхэд гол үүрэг нь чиглэгддэг тусдаа нэгжийг Төв банкинд бий болгох.

Бодлогын шийдвэр гаргах, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах болон шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцад Монгол Улсын санхүүгийн зах зээлд гол бодлого тодорхойлогч, зохицуулагч эдгээр байгууллагуудыг албан ёсоор багтаасан институцийн тогтолцоог цаашид бүрдүүлэх нь олон улсын сайн туршлагад нийцтэй бөгөөд, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх илүү боловсронгуй хувилбар юм. Түүнчлэн, Төв банкны хувьд энэхүү чиглэлээр мэргэшсэн боловсон хүчинээс бүрдсэн, үндсэн үүрэг нь макро зохистой бодлогын судалгаа, шинжилгээ, бодлогын санал боловсруулах ажлыг хариуцсан нэгжийг байгуулах нь олон улсын сайн туршлагатай нийцтэй болно. Үүнд шаардагдах хугацаа нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжил, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын санхүүгийн салбар, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, Төв банк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхэд явцад хуримтлуулсан туршлага, үр дүн зэргээс хамаарна.

## **VI. Олон нийттэй харилцах харилцаа**

Монголбанкны макро зохистой бодлогын талаар олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь Монголбанкны олон нийттэй харилцах бодлоготой нийцтэй байдлаар явагдана. Бодлогын ил тод, нээлттэй байдал болон олон нийттэй харилцах харилцаа нь Монгол Улсад макро зохистой бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал тулгуур байх болно. Нэг талаас санхүүгийн системд тулгарч буй эрсдэл, түүнийг оновчтой удирдахын тулд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнгийн талаар зах зээлд оролцогчид үнэн зөв, бодит мэдээлэлтэй байх нь төөрөгдлийг үүсгэхгүй, мэдээллийн дутагдал, мэдээллийн тэгш бус байдлаас болж ташаа мэдээлэл тархах эсхүл тодорхой бус

байдал үүсэхээс сэргийлнэ. Нөгөө талаас, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэгч институци илүү хариуцлагатай, ойлгомжтой, тууштай байх хөшүүргийг бий болгож, бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй юм.

Монголбанк нь макро зохистой бодлгоын талаар олон нийт, санхүүгийн зах зээлийн оролцогч, бусад бодлого шийдвэр гаргагч институцид дараах үндсэн аргаар хүргэнэ. Үүнд:

- 1. Макро зохистой бодлогын стратеги.** Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зарчмуудыг тайлбарласан энэхүү стратегийн баримт бичиг нь бодлогын эцсийн болон завсрлын зорилго, түүнд хүрэхэд ашиглах арга хэрэгсэл, үйл ажиллагааны зохион байгуулалт зэргийг олон нийтэд нээлттэй хүргэж, хэрэгжүүлэх бодлогын талаарх суурь ойлголттой холбоотой тодорхой байдлыг дээшшуулж буй. Макро зохистой бодлого нь манай улсын хувьд төдийгүй олон улсын туршлагад ч харьцангуй шинэ зүйл тул ойлгомжтой бөгөөд ил тод байх нь бодлогын үр дүнтэй байдалд зайлшгүй шаардлагатай. Монголбанк цаашид энэхүү стратегийг тасралтгүй хөгжүүлж, тогтмол сайжруулалтуудыг хийнэ.
- 2. Санхүүгийн тогтвортой байдлын тайлан.** Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой байдал, эрсдэлийн үнэлгээ, бодлогын үр нөлөөний үнэлгээг тусгасан уг тайланг Монголбанк тогтмол давтамжтай, урьдчилж товлосон хуваарийн дагуу нийтэлдэг. Санхүүгийн салбарын нөхцөл байдал, бодлогын тооцоо үндэслэл, үр нөлөөг олон нийтэд нээлттэй тайлагнах нь бодлогын хүрсэн амжилт, үр дүнг хэмжихэд чухал ач холбогдолтойн дээр бодлогын итгэл төрүүлэхүйц байдлыг нэмэгдүүлнэ. Монголбанк цаашид тайлангийн агуулга болон олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэнэ.
- 3. Төв банкны цахим хуудас дахь тусгай цэс.** Монголбанк нь албан ёсны цахим хуудсандаа макро зохистой бодлогын талаар төрөлжсөн тусгай цэсийг үүсгэн, олон нийтэд зориулсан мэдээллээр тогтмол баяжуулдаг. Тус цэсэнд макро зохистой бодлогын талаарх ерөнхий ойлголтоос эхлээд арга хэрэгслүүдийн талаарх тайлбар, макро зохистой бодлоготой холбоотой шийдвэрүүд, тайлангуудыг эмхэтгэн байршуулдаг. Цахим орчин дахь мэдээллийн түгээлт, тархац хүчтэй дэлгэрч буй, цаашид ч энэ байдал үргэлжлэх төлөвтэй тул энэхүү цэсийн гүйцэтгэх үүрэг роль цаашид нэмэгдэх хүлээлттэй байгаа бөгөөд Монголбанк сайжруулалт, шинэчлэлийн ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
- 4. Макро зохистой бодлогын шийдвэр ба хуралдааны тэмдэглэл.** Монголбанк нь макро зохистой бодлогын шийдвэр болон түүний үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл, шийдвэр гаргасан хуралдааны тэмдэглэлийг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар мэдээлнэ.
- 5. Бусад мэдээллийн суваг.** Монголбанк нь макро зохистой бодлогын үр нөлөөг дээшшуулж, зах зээлийн хүлээлтийг үр дүнтэй удирдахад дээрх харилцааны арга хэрэгслүүдийг ашиглахын зэрэгцээ бодлогын судалгаа, шинжилгээ, системийн нөлөө бүхий байгууллагуудтай хийх уулзалт, хурал, хэвлэлийн бага хурал зэрэг мэдээллийн сувгуудыг тухай бүр ашиглана.

## VII. Стратегид нэмэлт, өөрчлөлт оруулах

Монголбанкнаас Макро зохистой бодлогын талаар баримтлах стратегийг санхүүгийн зах зээлийн хөгжил, олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарсан ахиц дэвшил, өөрчлөлт, үүсч болзошгүй эрсдэлтэй уялдуулан тухай бүр өөрчлөх боломжтой байна. Стратегийг сайжруулах, дурдагдаагүй үлдсэн зохицуулалт, бодлогын арга хэмжээг шаардлагатай тохиолддолд нэмж тусгана.

----00----



Огноо: 2018 оны 3 дугаар сарын 23

Баримтын төрөл:

Тушаалын төсөл

Танилцсан: Ерөнхийлөгч

Н.Баяртсайхан

Хянасан: ХЭЗГ-ын захирал

Б.Ганбат

МБГ-ын захирал

Б.Баярдаваа

Боловсруулсан: Ажлын хэсэг

Б.Түмэнцэнгэл

## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

### Макро зохистой бодлогын стратеги батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 22<sup>1</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг, УИХ-ын 2017 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсад макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэх стратеги” -ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Макро зохистой бодлогын стратегийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчийн А-305 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг (Б.Түмэнцэнгэл)-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Д.Аюуш)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.Б.

Н.БАЯРТСАЙХАН